



**НИЙСЛЭЛИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2019 оны 02 сарын 11 өдөр

Дугаар A/17

Улаанбаатар хот

Ор хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/234, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны А/141 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төв”-д өдрийн эмчилгээний 50 ор нэмэлтээр, “Энхсаран” ХХК-ийн сувилалд сувиллын 30 ор нэмэлтээр, “Сорогзон” ХХК-ийн эмнэлэгт өвчний удаан явц, архаг үеийн 7 ор нэмэлтээр, “Нандин ухаан” ХХК-ийн эмнэлэгт өвчний хурцавтар үеийн 5 ор нэмэлтээр, “Гарьд манлай” ХХК-ийн эмнэлэгт өвчний удаан явц, архаг үеийн 5 ор нэмэлтээр, “Сор наран мед” ХХК-ийн эмнэлэгт өвчний хурцавтар үеийн 15 ор, “Егнин” ХХК-ийн эмнэлэгт өвчний архаг үеийн уламжлалтын 5 ор нэмэлтээр тус тус хуваарилсугай.

2. Эрүүл мэндийн байгууллагын батлагдсан орны хязгаарт багтаан үзүүлж буй тусламж, үйлчилгээнд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс /М.Мөнхдэлгэр/-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс /Г.Баянжаргал/-т даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

1150500032